



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/034/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Э.Энхбүрэн Утас: 7036-3036 Цахим хаяг: Enkhburene@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ-ҮРЖЛИЙН ЦӨМ
СҮРГИЙН АЖ АХУЙ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

2026-03-12 № СЭА-2026/034/НА-СТА-ОНӨҮГ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 20 дугаар зүйлийн 20.1.3, 31 дүгээр зүйлийн 1, 3.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээр алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй,
- Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, 2009 оноос хойш ашиглагдаагүй 10,000.0 мянган төгрөгийн

СЭА-2026/034/НА-СТА-ОНӨҮГ

3

4326050311

хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмжийг акталж, устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй,

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-т 2025 онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын гол асуудал

Тус газар нь тайлант оны орлого, зардлыг **95,208.1** мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр **62,574.4** мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэн, **66,769.2** мянган төгрөгийн зардал гаргаж, **4,194.8** мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь тайлант онд 4 зорилт, 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар 24-ны өдрийн Б/46 дугаар тогтоолоор биелэлтийг **70.0** хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь *(Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл)* санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,979.20	930,456.20
1.1.2	Дансны авлага	7,880,000.00	4,984,100.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	25,850.00
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	-	-
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө /мал/	19,333,000.00	18,613,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,226,979.20	24,553,406.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	14,658,617.25	10,937,365.75
1.2.2	Биет бус хөрөнгө	36,780,000.00	36,780,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	51,438,617.25	47,717,365.75
1.3	Нийт хөрөнгийн дүн	78,665,596.45	72,270,771.95
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг	450,000.00	450,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	7,432,997.00	5,055,612.00
2.1.1.3	Татварын өр	1,165,050.00	1,367,335.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	24,900.00	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,072,947.00	6,872,947.00
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,072,947.00	6,872,947.00
	ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.3	Өмч	41,615,000.00	41,615,000.00
2.3.1	-төрийн	41,615,000.00	41,615,000.00
2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,776,074.48	10,776,074.48
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	36,780,000.00	36,780,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(19,578,425.04)	(23,773,249.53)
2.3.11	Эздийн өмчийн дүн	69,592,649.44	65,397,827.95
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	78,665,596.44	72,270,771.95

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	52,452,615.00	36,848,875.00
2	Борлуулалтын өртөг	54,826,995.00	40,220,000.00
3	Нийт ашиг (алдагдал)	(2,373,380.00)	(3,371,125.00)
4	Түрээсийн орлого	1,573,000.00	300,000.00
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	24,795,500.00	25,425,500.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	22,484,508.50	(25,944,699.50)
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	3,343,500.00	(604,500.00)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	48,515.00	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,881,403.50)	(4,194,824.50)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,881,403.50)	(4,194,824.50)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,881,403.50)	(4,194,824.50)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(1,881,403.50)	(4,194,824.50)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	41,615,000.00	10,776,074.48	36,780,000.00	(19,578,425.04)	69,592,649.44
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
2	Залруулсан үлдэгдэл					

3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(4,194,824.50)	(4,194,824.50)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	2025 оны 06-р сарын 30-ны үлдэгдэл	41,615,000.00	10,776,074.48	36,780,000.00	(23,773,249.54)	65,397,824.94

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	55,075,130.00	60,044,775.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	35,075,130.00	37,148,875.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	20,000,000.00	20,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		2,895,900.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	55,715,616.00	59,128,298.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	33,329,103.00	41,632,835.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,900,400.00	8,231,100.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,674,895.00	3,099,100.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	657,307.00	300,000.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,290,000.00	1,465,400.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,293,461.00	4,059,113.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	570,450.00	340,750.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(640,486.00)	916,477.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(640,486.00)	916,477.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	654,465.20	13,979.20
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,979.20	930,456.20

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт					
2	Нийт орлого	төгрөг	95,208,100.00	62,574,375.00	32,633,725.00	65.7%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	төгрөг	38,900,600.00	40,220,000.00	(1,319,400.00)	103.4%
3	Нийт зардал	төгрөг	95,208,100.00	66,769,199.50	28,438,900.50	70.1%
	Үүнээс:	төгрөг	95,208,100.00	66,769,199.50	28,438,900.50	70.1%
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	төгрөг	40,220,000.00	40,220,000.00	0.00	100.0%
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	төгрөг	54,988,100.00	26,549,199.50	28,438,900.50	48.3%
4	Цэвэр ашиг, алдагдал	төгрөг	-	(4,194,824.50)	4,194,824.50	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **16,194.8** мянган төгрөгийн зөрчил илэрч, **14,194.8** мянган төгрөгийн 2 албан шаардлага, **2,000.0** мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **14,194.8** мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13,406.6 мянган төгрөгөөр давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр **4,194.8** мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.....*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*” журмын 4.2.1.10-т “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, 2009 оноос хойш ашиглагдаагүй **10,000.0** мянган төгрөгийн хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмжийг акталж, устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх “*Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас*

зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.”, 3.3 дахь “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 2,000.0 мянган төгрөгийн анхны үнэтэй 1 ширхэг хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ¹4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

2. Хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд цөм сүргийн малыг зах зээлийн үнээс хэт багаар үнэлж, бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 -д “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгээнэ” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

2.2 Өгсөн зөвлөмж: Цөм сүргийн малыг зах зээлийн бодит үнэд нийцүүлэн үнэлж бүртгэх саналыг дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх.

Дээрх зөрчлийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадаагүй алдагдалтай ажилласан	1	4,194.8			1	4,194.8						
Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгийг акталж, устгах	1	10,000.0			1	10,000.0						
Элэгдлээ бүрэн нөхсөн ашиглагдаж байгаа хөрөнгийг дахин үнэлээгүй.	1	2,000.0					1	2,000.0				
Эргэлтийн хөрөнгийг зах зээлийн ханшаас доогуур үнэлсэн.	1	-					1	-				
Дүн	4	16,194.8			2	14,194.8	2	2,000.0	1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 5 мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн.	1	-					1	-
Нийт дүн	1	-					1	-